БАТАЛГААЖУУЛАЛТЫН ХУУДАС

	Албан тушаал, нэр, гарын үсэг	Огноо
БАТАЛСАН:	ИРГЭНИЙ НИСЭХИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГА Э.ТӨРБАЯР	10/IV 2026
	ИРГЭНИЙ НИСЭХИЙН ҮНДЭСНИЙ ТӨВ ТӨХХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ Э.ЭНХЗОРИГ	10/IV 2026.
ХЯНАСАН:	ИНЕГ-ЫН ТӨЛӨВЛӨЛТ ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ДАРГА Ч.ОДГЭРЭЛ	01/IV 26
	ИНҮТ ТӨХХК-ИЙН ЕРӨНХИЙ МЕНЕЖЕР П.ГАНБОЛД	
БОЛОВСРУУЛСАН:	ИНЕГ-ЫН ТӨЛӨВЛӨЛТ, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН БАЙЦААГЧ С.БАТ-ЭРДЭНЭ	30/III 2026
	ИНҮТ-ИЙН АГААРЫН НАВИГАЦИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГАЗРЫН НИСЛЭГИЙН УРСГАЛ ТӨЛӨВЛӨЛТИЙН АЛБАНЫ ДАРГА Т.БАТБАЯР	17/III 26г.

ИРГЭНИЙ НИСЭХИЙН
ЕРӨНХИЙ ГАЗАР

ИРГЭНИЙ НИСЭХИЙН
ҮНДЭСНИЙ ТӨВ ТӨХХК

НИСЛЭГИЙН ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ ХАРИЛЦАН АЖИЛЛАГААНЫ ЗОХИЦУУЛАЛТЫН ЖУРАМ

УЛААНБААТАР ХОТ
2026 он

ӨӨРЧЛӨЛТИЙН БҮРТГЭЛ

Хэвлэлийн дугаар	Бүлэг, заалтын тайлбар	Өөрчлөгдсөн бичвэр	Өөрчлөлт оруулсан огноо
1		Анхны хувилбар	2026.03....

АГУУЛГА

1. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ
2. ХАМРАХ ХҮРЭЭ
3. НИСЛЭГИЙН ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ
4. НИСЛЭГИЙН ӨӨРЧЛӨЛТ, ЦУЦЛАЛТ, НЭМЭГДЭЛ
5. НИСЛЭГИЙН ЗӨВШӨӨРӨЛ, ТӨЛӨВЛӨЛТИЙН МЭДЭЭЛЭЛ СОЛИЛЦОХ СУВГУУД
6. ЖУРМЫН ХЭРЭГЖИЛТИЙГ ДҮГНЭХ
7. ХАРИУЦАХ АЖИЛТНУУД

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1 Энэхүү журам нь Монгол Улсын агаарын зайн болон нисэх буудлын багтаамжид нийцүүлэн нислэгийн хөдөлгөөний урсгалыг аюулгүй, үр ашигтай, төлөвлөх, шуурхай зохион байгуулах, дотоод, гадаадын агаарын тээвэрлэгчдэд Монгол Улсын агаарын зайд нислэг үйлдэх зөвшөөрөл олгох харилцааг зохицуулна.

1.2 Энэхүү журам нь Монгол Улсын Олон улсын иргэний нисэхийн тухай Чикагогийн конвенц, түүний хавсралтууд, Иргэний нисэхийн тухай хууль (Шинэчилсэн найруулга), Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 11 дүгээр сарын 27-ны өдрийн 189, 193 дугаар тогтоол, Зам, тээврийн сайдын 2024 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн А/289, А/290 дугаар тушаалыг тус тус үндэслэв.

ХОЁР. ХАМРАХ ХҮРЭЭ

2.1 Энэхүү журмаар Иргэний нисэхийн ерөнхий газар (цаашид "ИНЕГ" гэх) болон "Иргэний нисэхийн үндэсний төв" ТӨХХК (цаашид "ИНҮТ" ТӨХХК гэх) хооронд нислэгийн зөвшөөрөл олгох харилцан ажиллагааг зохицуулахад оршино.

2.2 Энэхүү журмаар улсын нисэхийн үйл ажиллагаанд зөвшөөрөл олгох харилцааг зохицуулахгүй.

ГУРАВ. НИСЛЭГИЙН ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ

3.1 Олон улсын хуваарьт нислэгийн хувьд ИНҮТ ТӨХХК-ийн Нислэгийн урсгал төлөвлөлтийн алба (цаашид НУТА гэх) нь агаарын тээвэрлэгчээс олон улсын хуваарьт өнгөрөлтийн нислэг, олон улсын нисэх буудалд хөөрөлт, буулт үйлдэх хуваарьт нислэгийн хүсэлтийг батлагдсан журмын дагуу хүлээн авч, боловсруулалт хийж тухай бүр ИНЕГ-т танилцуулан урт хугацааны нислэгийн төлөвлөлтөд тусгах зөвшөөрөл авна.

3.2 Олон улсын хуваарьт бус нислэгийн хувьд ИНҮТ ТӨХХК-ийн НУТА нь агаарын тээвэрлэгчээс олон улсын хуваарьт бус өнгөрөлтийн нислэг, олон улсын нисэх буудалд хөөрөлт, буулт үйлдэх хуваарьт бус нислэгийн хүсэлтийг батлагдсан журмын дагуу хүлээн авч боловсруулалт хийж ИНЕГ-т танилцуулан төлөвлөлтөд тусгах зөвшөөрөл авна.

3.3 Орон нутгийн хуваарьт нислэгийн хувьд ИНҮТ ТӨХХК-ийн НУТА нь агаарын тээвэрлэгчээс орон нутгийн хуваарьт нислэгийн хүсэлтийг батлагдсан журмын дагуу хүлээн авч, боловсруулалт хийж тухай бүр ИНЕГ-т танилцуулан урт хугацааны нислэгийн төлөвлөлтөд тусгах зөвшөөрөл авна.

3.4 Орон нутгийн хуваарьт бус нислэгийн хувьд ИНҮТ ТӨХХК-ийн НУТА нь агаарын тээвэрлэгчээс хуваарьт бус орон нутгийн нислэгийн хүсэлтийг батлагдсан журмын дагуу хүлээн авч, боловсруулалт хийж ИНЕГ-т танилцуулан төлөвлөлтөд тусгах зөвшөөрөл авна.

3.5 Онцгой үүрэг, тусгай үүрэг, албан захиалгат нислэгийн хувьд ИНЕГ нь гадаад харилцааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаар дамжин ирсэн нислэгийн хүсэлтийг батлагдсан журмын дагуу хүлээн авч, боловсруулалт хийж ИНҮТ ТӨХХК-ийн НУТА-нд хүргүүлж төлөвлөлтөд тусгуулна.

3.6 НУТА нь агаарын тээвэрлэгчээс ирүүлсэн хяналтгүй агаарын зайнаас хяналттай агаарын зайд, эсхүл хяналттай агаарын зайнаас хяналтгүй агаарын зайд нислэг үйлдэх

нислэгийн хүсэлт, холбогдох баримт бичгийг журмын дагуу хүлээн авч, хянан нислэгийн зөвшөөрөл олгоно.

3.7 ИНЕГ нь тус журмын 4.1, т заасны дагуу нислэгийн төлөвлөлт, гүйцэтгэл, бүртгэлийн ATFMS системийг ашиглан нислэгийн урсгал, төлөвлөлтийн менежментийн мэдээллийг хүлээн авч нислэгийн зөвшөөрлийг баталгаажуулна.

3.8 ИНҮТ ТӨХХК-ийн НУТА нь нислэгийн төлөвлөлт, гүйцэтгэл, бүртгэлийн ATFMS системийн мэдээллийн үнэн зөв байдал, хариуцан ажиллана.

3.9 ИНҮТ ТӨХХК-ийн Нисэхийн холбоо, навигаци, ажиглалтын алба нь нислэгийн төлөвлөлт, гүйцэтгэл, бүртгэлийн ATFMS системийн хөгжүүлэлт, шинэчлэл, засвар үйлчилгээ, найдвартай ажиллагааг хариуцан ажиллана.

ДӨРӨВ. НИСЛЭГИЙН ӨӨРЧЛӨЛТ, ЦУЦЛАЛТ, НЭМЭГДЭЛ

4.1 НУТА нь агаарын тээвэрлэгчдээс ирүүлсэн нислэгийн урт хугацааны өөрчлөлт, нэмэгдлийг "Нислэгийн хөдөлгөөнийг төлөвлөх, зөвшөөрөл олгох журам"-ын холбогдох заалтад нийцүүлэн хүлээн авч, боловсруулан ИНЕГ-ын зөвшөөрлийн хүрээнд баталгаажуулна.

4.2 Агаарын тээвэрлэгчдээс ирүүлсэн урьдчилсан болон шуурхай төлөвлөлтийн үе шатуудад нислэгийн өөрчлөлт, цуцлалт, нэмэгдлийг "ИНҮТ" ТӨХХК-ийн НУТА нь "Нислэгийн хөдөлгөөнийг төлөвлөх, зөвшөөрөл олгох журам"-ын холбогдох заалтад нийцүүлэн баталгаажуулна.

4.3 ИНҮТ ТӨХХК-ийн НУТА нь агаарын зайн багтаамж, нисэх буудлын багтаамжид нийцүүлэн урьдчилсан болон шуурхай төлөвлөлт хийнэ.

ТАВ. НИСЛЭГИЙН ЗӨВШӨӨРӨЛ, ТӨЛӨВЛӨЛТИЙН МЭДЭЭЛЭЛ СОЛИЛЦОХ СУВГУУД

5.1 ИНЕГ, ИНҮТ ТӨХХК-ийн НУТА нь нислэгийн урсгал, төлөвлөлт болон менежментийн мэдээллийг "DOC share" ашиглан дараах агуулламжтай солилцоно. Үүнд:

- Нислэгийн тоо
- Аяллын дугаар
- Агаарын хөлгийн маяг
- Огноо
- Нислэгийн хүсэлт ирсэн огноо
- Зөвшөөрөл олгосон огноо
- Зөвшөөрлийн дугаар
- Агаарын зам
- Хүсэлт ирүүлсэн агаарын тээвэрлэгч
- Нислэгийн зорилго

5.2 ИНҮТ ТӨХХК-ийн НУТА нь нислэгийн төлөвлөлт, гүйцэтгэл, бүртгэлийн ATFMS системийн хэрэглэгчийн эрхийг ИНЕГ-т үүсгэн өгч, нислэгийн урсгал, төлөвлөлтийн менежментийн мэдээллээр тогтмол хангана. Үүнд:

- Нислэг захиалга
- Аялал төлөвлөх
- Зөвшөөрөл олгох

- Нислэгийн төлөвлөлт
- Урьдчилсан төлөвлөлтийн нислэгийн мэдээ

ЗУРГАА. ЖУРМЫН ХУГАЦАА, ХЭРЭГЖИЛТИЙГ ДҮГНЭХ

6.1 Энэхүү журмыг 3 жилийн хугацаатай дагаж мөрдөх бөгөөд журмын хэрэгжилтийг жил бүрийн эцэст талууд хамтран дүгнэнэ.

6.2 Томилогдсон ажилтнууд энэхүү журмын хэрэгжилтийг улирал тутам дүгнэж, удирдлагад танилцуулах бөгөөд шаардлагатай арга хэмжээг авч ажиллана.

ДОЛОО. ХАРИУЦАХ АЖИЛТНУУД

Байгууллага	Үндсэн хариуцагч	Хоёрдогч хариуцагч	Томилогдсон ажилтнууд
ИРГЭНИЙ НИСЭХИЙН ЕРӨНХИЙ ГАЗАР	ДАРГА Э.ТӨРБАЯР	ТӨЛӨВЛӨЛТ, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ДАРГА Ч.ОДГЭРЭЛ	ТӨЛӨВЛӨЛТ, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН БАЙЦААГЧ С.БАТ-ЭРДЭНЭ
ИРГЭНИЙ НИСЭХИЙН ҮНДЭСНИЙ ТӨВ ТӨХХК	ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ Э.ЭНХЗОРИГ	ЕРӨНХИЙ МЕНЕЖЕР П.ГАНБОЛД	НИСЛЭГИЙН УРСГАЛ ТӨЛӨВЛӨЛТИЙН АЛБАНЫ ДАРГА Т.БАТБАЯР

--- oOo ---